



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 151

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах
тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дах заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Экспорт-Импорт банк хооронд байгуулсан “Үндэсний оношилгоо эмчилгээний төв байгуулах төсөл”-ийн Зээлийн гэрээний дагуу тус төслийн барилгын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж нийлүүлэх, сургалт зохион байгуулах, эрүүл мэндийн мэдээллийн систем болон зайн оношилгооны тоног төхөөрөмж нийлүүлэх компанитай байгуулах гэрээний хэлцлийг хийх Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Б.Эрдэнэчимэг, Эрүүл мэнд, спортын яамны /ЭМСЯ/ Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нарийн бичгийн дарга: А.Учралт, Үндэсний оношилгоо эмчилгээний төв байгуулах төслийн орчуулагч, сургалт хариуцсан ажилтан

Гишүүд: Л.Зэндмаа, ЭМСЯ-ны Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Ж.Амаржаргал, ЭМСЯ-ны салбарын ерөнхий нягтлан бодогч

С.Батбаатар, ЭМСЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын Хууль эрх зүйн мэргэжилтэн

2. Ажлын хэсгийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны даалгаврыг хавсралтаар баталсугай.

3. “Үндэсний оношилгоо эмчилгээний төв байгуулах төсөл”-ийн барилгын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж нийлүүлэх, сургалт зохион байгуулах, эрүүл мэндийн мэдээллийн систем болон зайн оношилгооны тоног төхөөрөмж нийлүүлэх компанитай

080521

хийх гэрээний хэлцлийг БНСУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагааны сангийн худалдан авах ажиллагааны журам, холбогдох хууль, дүрэм журмын дагуу зохион байгуулахыг Ажлын хэсгийн ахлагч /Б.Эрдэнэчимэг/-д даалгасугай.

4. Холбогдох бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлэхийг Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга /А.Учралт/-д үүрэг болгосугай.


САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

Эрүүл мэнд, Спортын сайдын
2015 оны 04 сарын 20-өдрийн
157 дугаар тушаалын хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ДААЛГАВАР



1. Гэрээний ерөнхий нөхцлийг талууд заалт бүрээр харилцан ойлголцох
2. Гэрээний тусгай нөхцлийг нарийвчлан хэлэлцэх: Үүнд:
 - 2.1 Зөвшөөрөл, магадлан итгэмжлэл, гаалийн татварын асуудлыг засгийн газар хариуцах
 - 2.2 Төсөвт өртөгөөс хэтэрсэн 2,107,000 долларын асуудал болон гэрээний үнийн дүнг журмын дагуу тохирох,
 - 2.3 Төлбөрийн нөхцөл болон төлбөрийн хуваарийг ЭКЗИМ банкны баталсан хуваарийн дагуу хийх
3. Экзим банкны баталсан тендерийн баримт бичгийн 1-р зүйлийн 35.4 дэх заалтын дагуу туслан гүйцэтгэгчийг ЭМСЯ ажил олгогчийн хувьд батлах
4. Ажил олгогч дараах шаардлагыг тавина. Үүнд:
 - 4.1 Сургалтын хөтөлбөрийг өөрчлөх талаар

	ТЭЗҮ	Тендерийн баримт бичиг	Шинээр дэвшүүлж буй санал
Сургалтын чиглэл	Эмнэлгийн менежментийн сургалт	Эрүүл мэндийн салбарын Шийдвэр гаргагч болон менежерийн сургалт	Циклотроны үйлдвэрт ажиллах үндсэн мэргэжилтний сургалт
Хаана	Солонгос	Солонгос	Солонгос
Хугацаа	1-3 өдөр	5-21 хоног	6 сараас 1 жил хүртэл
Сургалтанд хамрагсдын тоо	10 хүн	12 хүн	4 хүн

4.2 Барилгын ажлын талаар

- Зоорийн давхрын төлөвлөлтөд өөрчлөлт оруулах: Циклотроны үйлдвэрийг барилгын зоорийн давхарт байршуулах
- Барилгын цонхны онгойлт, салхивчийг Монгол Улсад мөрдөгдөж байгаа Эрүүл ахуйн норм, дүрэм, стандартын шаардлагад нийцүүлэн төлөвлөх,
- Төлөвлөлтийн шийдлийг Монгол Улсад мөрдөгдөж байгаа Галын аюулгүй байдлын норм, дүрэм, стандартын шаардлагад нийцүүлэх,
- Батлагдсан эх загвар зурагт тусгагдсан мэс засал, СТ болон ангиографийн өрөөний тоог цөөлөх үндэслэл, боломж байгаа эсэх талаар ярилцах